БАТЛАВ:
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ П.АРИУНБАТ
2021 ОНЫ 10 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР

ХӨВСГӨЛ АЙМГИЙН МӨРӨН СУМАНД "ХӨВСГӨЛ ЭРЧИМ ХҮЧ"ХХК-ИЙН ОФФИСЫН БАРИЛГЫН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2021.10.18 № ЗД-2021/159 Мөрөн сум

1	Зураг ,төсөв зохиох үндэслэл	Хөвсгөл аймгийн "Хөгжсөн Хөвсгөл" 2016-2030 он хөтөлбөр
2	Барилга байгууламжийн нэр, байршил	Хөвсгөл аймгийн Мөрөн суманд "Хөвсгөл эрчим хүч" ХХК-ийн оффисын тэнхлэгээрээ 14.5м*30.4м хэмжээтэй 2 давхар барилга
3	Зориулалт, хүчин чадал	150 хүүхдийн хүчин чадалтай тэнхлэгээрээ 24м*28м хэмжээтэй 2 давхар зоорийн давхаргүй барилга.
4	Барилга байгууламжийн бүрэлдэхүүн	**1 дүгээр давхар:** • Гонх • Коридор • Шатны хонгил • Ашиглалтын инженер болон монтёруудын өрөө • Диспетчер реле хамгаалалтын ахлах инженерийн өрөө • Борлуулалтын нягтлан бодогчын өрөө • Тоолуурын инженер болон лабораторийн өрөө • Архив • Цайны газар • Гэрээт танхим • Дуудлагын үйлчилгээ • Үйлчилгээний заал • Борлуулалтын ахлах инженерийн өрөө • Ариун цэврийн өрөө /эрэгтэй, эмэгтэй/ • Дулааны өрөө • Цахилгааны өрөө **2 дугаар давхар:** • Коридор • Шатны хонгил • Бичиг хэргийн ажилтны өрөө • Гүйцэтгэх захирлын өрөө • Ерөнхий нягтлан бодогчын өрөө • Ерөнхий инженерийн өрөө • Амралтын өрөө • ХАБЭА-н инженерийн өрөө

		• Дэд захирлын өрөө • Нярвын өрөө • Эдийн засагч, тооцооны нягтлан бодогч, ХААХ ажилтны өрөө • Ариун цэврийн өрөө /эрэгтэй, эмэгтэй/ Мөн 1-2 дугаар давхарт аваарын шаттай байна. Гадна тохижилтын ажлыг бүрэн тусгана. Авто машины зогсоолтой байна. Мөн дараах норм дүрмийн дагуу төлөвлөнө. • Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм дүрэм /БНбД 30-01-04/ • Олон нийтийн барилгын норм дүрэм /БНбД 31.03.03/ • Сургалт хүмүүжлийн барилгын норм ба дүрэм /БНбД II.66.88/ • Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм /БНбД 3.01-06-90/ • Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөч, зам, налуу шатыг шийдэх /MNS 6056:2003, 6055-2009 • Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм • Барилга доторх усан хангамж, ариутгах татуурга БНбД 40-05-98 Бусад холбогдох норм, дүрэм
5	Барилгын үндсэн бүтээц, материал	**Суурь:** Цутгамал төмөр бетон шугаман суурь /Цутгамал төмөр бетоны ажлыг БНбД 83-4Б-01/ **Үндсэн бүтээц:** Цутгамал төмөр бетон арагт бүтээцтэй. /БНбД 83-4Б-01/ **Хана:** Блокон гулдмайгаар өрж, хөөсөн полистирол хавтангаар дулаалж, өнгөлгөөний металл гадна фассад хийх. Дотор даацын болон даацын бус ханыг ердийн улаан тоосгоор өрөх. /Барилгын дулаан техникийн БНбД 31-02-03, дуу, дулаан тусгаарлалтын ажил БНбД 31-08-05, Өргийн ажлын БНбД 83-3а-01/ **Хучилт:** Цутгамал төмөр бетон хучилт /Цутгамал төмөр бетоны ажлыг БНбД 83-4Б-01/ **Дээвэр:** Хавтгай дээвэр төлөвлөнө. Дээврийн хучлага БНбД 31-02-03, дээврийн ажил БНбД 31-07-05 норм дүрмүүдээс холбогдох заалтуудыг авч төлөвлөх. **Цонх:** 3 давхар шилтэй хуванцар рамтай MNS 5830:2008, MNS 5802:2007 стандартуудыг хангасан, "Хүүхдийн цэцэрлэгийн аюулгүй байдлын дүрэм"-ийн дагуу хүүхэд унаж бэртэхээс сэргийлж салхивчийг цонхны дээд хэсэгт 40см*40см-ийн хэмжээтэй цонх тус бүрд 2 салхивчийг хийнэ. **Хаалга:** Гадна хаалгыг дулаалгатай металл хаалга хийх дотор хаалгыг стандартын шаардлага хангасан

		сайн чанартай, зориулалтын, шинэ дэвшилтэт материал ашиглахаар төлөвлөх. Хаалганууудыг стандартын дагуу бүгдийг гадагш түлхэж онгойдгоор төлөвлөж өгөх. **Ялуу:** Гадна дотор хананд гаргах хаалга, цонхны нүхэн дээр үйлдвэрийн угсармал ялууг 50 маркын зуурмаг дээр угсарна. **Шал:** Өрөөнүүдийг зориулалтаас нь хамааруулж /мозайк, боржин чулуу, плита, паркет, дрож / зэрэг орчин үеийн сайн чанартай материал сонгож төлөвлөх. **Дотор засал:** Бүх ханын гадаргууд сайжруулсан шавардлага хийж, сайн чанарын орчин үеийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй барилгын стандарт норм дүрэм нийцсэн материал сонгож төлөвлөх ба дотор будгийг шалнаас тааз хүртэл будах. Заслын ажил /БНбД31-10-05/ **Тааз:** Барилгын бүх таазанд сайн чанарын тэгшилгээ шавар хийж хүүхдийн эрүүл ахуйн шаардлага хангасан эмульсээр 2-3 давхарлаж эмульсдэж өгөх. **Агаар сэлгэлт:** Тооцооны үндсэн дээр оновчтой төлөвлөсөн агааржуулалтын системтэй төлөвлөж өгөх. **Гадна засал:** Гадна нүүр талд шилэн фассад төлөвлөх. Гадна бусад 3 талыг металл фассад төлөвлөх. Мөн барилгын усны хаялга, парпетны малгайвч, хаяавч, аянга зайлуулагч зэргийг барилгын гадна засалтай уялдуулан өнгө үзэмжтэй, чанартай төлөвлөх. **Холбоо дохиолол:** Тооцооны үндсэн дээр утаа мэдрэгч, галын дохиолол, галын гидрат, интернет, камерын системийг төлөвлөж өгөх. **Дотор цахилгаан:** Дотор гэрэлтүүлгийн ажлыг галын аюулгүй байдлын нөхцөлийг бүрэн хангаж тод чанартай гэрэлтүүлэг төлөвлөх. Аюулгүй байдал талаас нь бүрэн хангах. "Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг" БНбД 23-02-08 **Дотор сантехник:** Барилгын дотор сантехникийн халаах хэрэгслийг усны хатуулагт тохирсон халаах хэрэгслийг тооцооны үндсэн дээр төлөвлөх. Халаах хэрэгсэлд бүгдэд нь тохируулгатай хаалт тавьж өгөх. Барилга доторх усан хангамж, ариутгах татуурга БНбД 40-05-98 **Гадна тохижилт:** Гадна тохижилтын явган зам талбай, зүлэг зэргийг орчны зам талбайтай уялдуулан төлөвлөх. Авто зогсоол ачааллыг тооцож төлөвлөж өгөх. "Хот тосгоны төлөвлөлт" БНбД 30-01-04 стандарт норм дүрмээс холбогдох заалтыг авч төлөвлөх.
6	Инженерийн шугам сүлжээ, түүнийг хангах эх үүсвэр (дулаан,	**Цахилгаан хангамж:** Техникийн нөхцөлөөр **Дулаан хангамж:** Техникийн нөхцөлөөр

	усан хангамж ариутгах татуурга, цахилгаан холбоо, инженерийн хангамж)	**Цэвэр ус:** Техникийн нөхцөлөөр **Холбоо дохиолол:** Техникийн нөхцөлөөр **Ариутгах татуурга:** Техникийн нөхцөлөөр
7	Зураг төслийн иж бүрдэл	<u>1. Баримт бичгийн иж бүрдэл</u> • Инженер геологийн дүгнэлт • Байр зүйн дэвсгэр зураг боловсруулах • Онцгой байдлын дүгнэлт • Магадлалын ерөнхий дүгнэлт /хавсралт дүгнэлтийн хамт/ <u>Зургийн төслийн иж бүрдэл</u> 2. Эскиз /батлагдсан/ 3. Ажлын зураг /батлагдсан/ • ЕТ – Ерөнхий төлөвлөгөө • БА- Барилга архитектур • ТХ – Технологийн зураглал • ББ – Барилга бүтээц /Бүтээцийн тооцооны хамт/ • ХАС – Халаалт агаар салхивч • ЦБУ – Цэвэр бохир ус • ДГ- Дотор гэрэлтүүлэг • ХТ- Хүчит төхөөрөмж • ХД – Холбоо дохиолол • ГД – Гадна дулаан хангамж • УХАТ –Ус хангамж ариутгах татуурга • ГЦ- Гадна цахилгаан хангамж 4.Барилгын төсөв /батлагдсан/
8	Зураг төсөв зохиох үе шат	• 1 үе шаттай • Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
9	Зураг төслийн байгууллага	" Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" Монгол улсын хуулийн дагуу зөвлөх үйлчилгээгээр сонгон шалгаруулна. Зураг төслийн тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж зураг төсөл боловсруулах дүрмийн дагуу /БНбД 11-01-98/ хийж гүйцэтгэнэ.
10	Хөрөнгө оруулагч байгууллага	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар
11	Барилга угсралтын ажлыг гүйцэтгэх хугацаа	2022 он
12	Онцгой нөхцөл	• Үер ус, аянга цахилгаанаас урьдчилан сэргийлэх байдлыг хангасан байна. • Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм БНбД 22-01-01-ийн 2.5-ын 4-р хүснэгтийн 5-д заасан үндэслэлээр газар хөдлөлтийг тооцох

		• Барилгын аврах гарцыг норм дүрмийн дагуу төлөвлөх ба саадгүй, түргэн аврагдах гарцыг төлөвлөх. • Галд шатдаг материал барилгын үндсэн хийцэд ашиглахгүй байх. • Барилгын дотор заслыг эко орчин бүрдүүлсэн ,өнгө үзэмжтэй байх. • Зураг хийхдээ захиалагч талтай зөвшилцөж, газар дээр нь хэмжилт хийх. • Харагдах байдал, гадна орчны өнгө үзэмжийг одоо байгаа барилгуудтай уялдуулна. • Зургийн үнэ болон техникийн нөхцөлүүдийн үнийг төсөвт оруулж өгөх. • Инженер геологийн зардлыг төсөвт тусгаж өгөх.
13	Галын аюулгүй байдлын нөхцөл	" Барилга байгууламжийн галын аюулгүй байдал" БНбД 21-01-02 , "Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм" БНБД 21-02-02 ," норм дүрмүүдээс холбогдох заалтуудыг авч төлөвлөнө.
14	Байгаль орчны үнэлгээ	Шаардлагатай нөхцөлд үнэлгээг тухай бүрт нь хийлгэнэ.
15	Эдийн засгийн тооцоо, төсөв, ТЭЗҮ	БНбД 81-95-12 төсөв зохиох дүрмийн дагуу төсвийн ESTIMATOR-PRO программ болон түүнтэй ижил эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцсон байна.

ХЯНАСАН:
АЙМГИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР: / Х.ДАВААСҮРЭН /

АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА: /Б.ЭНХЖАРГАЛ/

ЗУРГИЙН ДААЛГАВАР БОЛОВСРУУЛСАН:
АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН: /У.ХҮЧИТБААТАР/